

“Манж анатоми”-ийн монгол сурвалж бичгийг харьцуулан судлахуй

Гэрэлмаа Б.¹, Дагданбазар Б.¹, Шагдарсүрэн Д., Болд Ш.²
¹“Ач” АУИС, ²Долмалин эмнэлэг, ³АШУУИС-ийн МАУОНС

Abstract

Comparative Study of Mongolian sources of Manchu Anatomy

Gerelmaa.B¹, Dagdanbazar.B¹, Shagdarsuren.D and Bold.Sh²

¹“Ach” Medical University, ²Dolmalin Hospital

³International School of Mongolian Medicine,
 Mongolian National University of Medical Sciences

In 1687 the first contingent of French Jesuits Joachim Bouvet (1656-1730) and others arrived in Manchu Qing dynasty, then under the reign of Kangxi (Enkh-Amgalan khaan). Bouvet and Gerbillon elected to remain in Beijing. Five years after they came, Kangxi was forty years of age (in 1692), he had malaria and could not be cured by medicine. A Jesuit priest presented quinine to Kangxi who was cured by this medicine. Having personally sampled and benefited from Western medicine, the Emperor became very interested in the foreigners' science. He ordered Bouvet to prepare for his instruction a treatise on anatomy. The anatomy project was not resumed, for Bouvet soon departed for France. The task was later completed by another Jesuit, Dominique Parennin (1665-1741), who arrived in China in 1698. To serve as the blueprint for his assignment, Parennin chose the text of one of the standard works on anatomy in Europe at that time, written by Pierre Dionis, which he considered to be the most exact and clear. However, for the illustrations he preferred the text of the Dane, Thomas Bartholin [1]. Thus, the “Manchu anatomy” created based on the books of European anatomy in Manchu dynasty.

The significance of this research work is that Manchu anatomy was the first attempt to try to combine Western and Oriental medicine and also to be a modern anatomy base of the methods of traditional medicine. On the other hand, it can be said it is the first initiation to combine principles and views of Western medicine and Traditional Mongolian medicine.

The book “Manchu anatomy” was translated from Manchu language into Mongolian by Mongolian scholars as the title of “Imperial-Commissioned Complete Record on the Body.” We consider that this translation is completed one including 2 volumes and 6 chapters. Currently, it is impossible to tell the exact time when it was translated. However, we hope that to determine the exact time of the translation could be found further study. Later, in 1929, another version of Mongolian script was published in Inner Mongolia by the name of “Imperial-Commissioned ge ti ciovian lu bichig.” But it is not completed translation.

End of study we concluded that the “Manchu anatomy” is not only anatomical book based on European anatomical book but also it covers some knowledge of Oriental medicine. For example, Tibetan and Sanskrit names of medicine and their ingredients are in this book. Mongolian medicinal names originated from the animals, especially the names of internal organs which are not used in European countries. Most commonly, human body in this book divided into 5 vital organs and 6 hollow organs in accordance with black astrology of Oriental Medicine and expressed the connection among the embryo, body, and structure in the Western medical theory.

Key words: Manchu anatomy, translation and Western medicine

Pp. 117-124, Figures 4, Tables 2, References 14

Удиртгал


1687 онд Манжийн Энх-Амгалан (1662-1722 он) хааны засаглалын үеэр Францын Есүсийн нийгэмлэгийн гишүүдийн анхны элч нар Манж Чин гүрэнд иржээ. Эдгээр элчээс Бүвет, Гербиллон нар Бээжин хотод үлдэхээр

сонгогдов. Тэд эзэн хааны итгэлийг олж, арифметик, Эвклидийн элементүүд, практик геометр болон философи зэрэг европын мэдлэг, ухааныг заан сургах багш нар нь болсон байна. Энх-Амгалан хаан 1692 онд 40 настай байхдаа хумхаа өвчнөөр өвджээ. Хаан ордны эмч нарт

үзүүлж эм уусан ч сайжралыг олоогүй ажээ. Энэ тохиолдол нь барууны анагаах ухааныг ойлгуулах, бишрэлийг төрүүлэх, дэлгэрүүлэх чухал мөч болсон байна. Шашны элч нарын хяналт сайтай, үр дүнтэй эмчилгээний дараа хааны амь насыг аварч, энэ мэдээг олон түмэнд зарлаж, тэднийг хааны ордны доторх том харшаар шагнав. Энх-Амгалан хааны гадаадын шинжлэх ухааныг сонирхох явдал улам нэмэгдэв. Тэрбээр Бүветэд анатомийн тухай анагаах ухааны бүтээл бэлтгэхийг тушааж, удалгүй анатоми заалгаж эхлэв. Гэвч Бүвет Франц руу буцах болсон тул анатомийн хичээл заах ажил түр зогсжээ [2].

1698 онд Манжид ирсэн Доминик Пареннин (1665-1741) хэмээх өөр нэг элч уг ажлыг үргэлжлүүлэн дуусгасан байна. Тэрбээр хичээл заахын зэрэгцээ хааны зарлигаар анатомийн ном бичих ажлыг эхлүүлжээ. Доминик Пареннин тухайн үедээ хамгийн нарийн, тодорхой бичигдсэн гэгддэг, Европийн анатомийн стандарт бүтээлүүдийн нэг Пиер Дионисийн номыг [3] сонгон авчээ. Харин жишээ зургийн хувьд Данийн Томас Бартолинийн номыг [4] илүүд үзжээ (Зураг 1, 2). Номоо 5

жил бичсэн бөгөөд энэ хугацаанд эзэн хаан гурван хятадач, хоёр бичээч, хоёр зураач гарган өгч туслуулав. Уг бүтээл дууссаны дараа эзэн хаан хэвлэх зөвшөөрөл өгсөнгүй. Тэр ч бүү хэл гар бичмэлийг унших эрхийг хэдхэн хүмүүст олгон, тэдэнд номыг ордноос авч гарах, эсвэл тэмдэглэл хөтлөх зөвшөөрөл олгохгүй байв. Нийт гурван хуулбарыг гараар бичиж, Бээжин хотод нэг, нийслэлээс гаднах Цэнгэлдэх ордонд нэг, гурав дахийг нь Манжийн өвөг дээдсийн онгон Жехолд тус тус хадгалжээ. Харин Доминик Пареннин нэгэн тусгай хуулбарыг өөрийн гишүүн байсан Парис дахь Шинжлэх Ухааны Академид илгээжээ. Парисын хуулбар нь олон зууны турш европт байгаа цорын ганц хуулбар юм. Европт уг номыг “Манж анатоми” хэмээн алдаршуулж, олон арван судалгааны бүтээл хэвлүүлсэн байдаг. “Манж анатоми”-ийн номыг Ар Монголчууд “Дээрээс тогтоосон дүрс тус бүрийг бүртгэсэн бичиг” (ДТДТБББ) [5] нэрээр манж хэлнээс монгол хэлээр харин Өвөр Монголд “Зарлигаар тогтоосон хэ ти чиуван лу бичиг” (ЗТХТЧЛБ) [6] нэрээр мөн манж хэлнээс орчуулж 1929 онд хэвлүүлжээ (Зураг 3, 4).



Зураг 1. Pierre Dionis
Anatomie de l'Homme



Зураг 2 Thomas Bartholin
Anatome ex omnium veterum
recentiorumque observationibus



Зураг 3. Дээрээс тогтоосон дүрс тус бүрийг бүртгэсэн бичиг

Иймээс эдгээр бүтээлүүдийг харьцуулан судлах нь Монголын анагаах ухааны түүхийг баяжуулаад зогсохгүй Монголд Европийн анагаах ухаан дэлгэрсэн үеийг зөв тогтоох, цаг хугацааг урагшлуулах боломжтой болох юм.

Зорилго

“Манж анатоми”-ийн өнөөгийн байдлаар олдоод байгаа хоёр гол орчуулга болох “Дээрээс тогтоосон дүрс тус бүрийг бүртгэсэн бичиг” болон “Зарлигаар тогтоосон хэ ти чиуван лу бичиг”-ийг харьцуулан судлах


Материал, арга

1. Судалгааны гол материал

- Dergici toktobuha ge ti ciovann lu bithe. Манж хэлээр бичсэн гар бичмэл хуулбар ном;
- Дээрээс тогтоосон дүрс тус бүрийг бүртгэсэн бичиг. (эрх. Б.Ринчен). ШУА-ийн Хэвлэх үйлдвэр, УБ, 1971
- Зарлигаар тогтоосон хэ ти чиуван лу бичиг. (Хян. Балдандончир). БНХАУ, ӨМ-ын ШУТМХ, 1986

2. Судалгааны арга

- Эх бичиг, сурвалж бичгийн судлал
- Судалгаанд ашигласан хэрэглэгдэхүүнээ



Зураг 4. Зарлигаар тогтоосон хэ ти чиуван лу бичиг

ажлынхаа зорилго, зорилттой нийцүүлэн хамгийн эрт үеэс нь эхлэн цаг хугацаагаар нь эрэмбэлэн судалгааг хийж улмаар гол агуулга, сэтгэлгээний хувьд онцгой шинэлэг, эргэлт гарахуйц санаа, нэр томъёог хооронд нь харьцуулан, шүүн тунгааж үзлээ. Мөн судалгааны бүтээлийн уламжлал шинэчлэлийн асуудалд улирал дэвших диалектик зүйн тогтнолын үүднээс хандахдаа В.Ф.Гегель (1837), Н.И.Конрид (1966), Л.Н.Гумилев (1989), Н.Хавх (1995) нарын үзэл баримтлалын ерөнхий чиг зарчмыг баримталж ажиллав.

- Түүхэн харьцуулалтын арга

“Манж анатоми”-ийн номын монгол орчуулга, нэр томъёог төрөлжүүлэн хувааж хооронд нь харьцуулах, судалгааны бүтээлийн агуулга, орчуулгын ялгаатай, төсөөтэй талууд, онолын мэдлэг нь хэрхэн уламжлан дамжиж ирснийг илрүүлэхэд энэхүү аргыг хэрэглэлээ.

- Нэг төрлийн объект болох хүний биеийн бүтэц зүйн тогтолцоо, онцлогийг судлах арга

Бидний судалгааны үндсэн объект болох хүний биеийн бүтэц зүйн мэдлэгийг

Европийн анагаах ухааны анатомийн судалгааны гол арга гэгддэг задлан шинжлэх, хэсгээс бүхлийн талаарх мэдээлэл олж авдаг аргаар (индукц) судлан, монголчууд эдүгээгээс олон арван жилийн тэртээ орчуулсан номыг тухайн цаг үед нь баримталж ирсэн үзэл баримтлалын дагуу судалгааг явуулав. Түүнчлэн Дорно дахины анагаах ухаан дахь хүний биеийн бүтэцзүйн учир шалтгаан (логик), язгуур үндэс, нэр томъёог харьцуулан жишиж, хүний бие махбодын талаарх үзэл баримтлалын мөн чанар, онол арга зүйн үндсийг тогтооход энэхүү аргыг хэрэглэв.

Үр дүн

Судалгааны ажлын эхний хэсгээ бид орчуулгын бүтээлийн үсэг бичиг, үг хэллэгийг тайлбарлахад чиглүүлэв.

Барууны судлаачид Манжийн Энх-Амгалан ер бусын сэтгэдэг, шинжлэх ухаанд дур сонирхолтой, шинжлэх ухааныг хөхиүлэн дэмждэг байсан ч «Манж анатоми»-ийн ач холбогдлыг төдийлөн ойлгож чадаагүйгээс уг номыг хэвлүүлээгүй хэмээн үздэг. Хэрэв хаан уг номыг хэвлүүлэн түгээсэн бол Европын анагаах ухаанд Везалийн “Фабрика” (1543) [7] хэмээх анатомийн ном хувьсгал хийсэнтэй адил тухайн үедээ Манж, Хятад, Монголын анагаах ухаанд хувьсгал хийх байжээ [8].

«Манж анатоми»-ийн номыг Монголчууд манж гар бичмэл эхээс [9] нь “Дээрээс тогтоосон дүрс тус бүрийг бүртгэсэн бичиг” нэрээр монгол хэлээр орчуулж, гар бичмэлээр хэрэглэж байв. Хожим нь 1929 онд Өвөр Монголд “Зарлигаар тогтоосон хэти чиуван лу бичиг” нэрээр орчуулж монгол бичгээр хэвлүүлжээ.

Монголд байсан “Дээрээс тогтоосон дүрс тус бүрийг бүртгэсэн бичиг” хэмээх хоёр боть, 6 дэвтэр бүтээлийг чухам хэдий үед орчуулсныг одоогоор тогтоож амжаагүй байна. Магадгүй Фонтанейн хэлснээр: “Тэд өөрсдийн заах сургалтын материалаа татар хэлээр бичдэг байсан. Дараа нь уг материалаа эзэн хаанд тайлбарлаж өгдөг бөгөөд хаан тэдний зааж байсан хичээлийг сайн ойлгож, бидний шинжлэх ухааныг улам биширч байлаа” [10] хэмээсэнд үндэслэн Энх-Амгалан хааны үед монгол гар бичмэлээр байсан гэж таамаглах боломжтой юм. Гэхдээ бид энэ таамаглалаа гүнзгийрүүлэн судалж батлагдах таамаг гэж үзсэнгүй. Нируны хаант улс 555 онд мөхсөний дараа монгол хэлт нүүдэлчин аймгуудын нэгдлийг Гучин Татар гэж нэрлэжээ. Ер нь харь улсууд Монгол, Манж зэрэг

нүүдэлчдийг багтаасан улсуудыг татар хэмээн дуудах нь олонтоо байв. Үүнээс улбаалаад худам монгол бичгийг татар бичиг гэж үздэг байсан ч Манж Чин улсыг үндэслэгч Нурхач, Эрдэнэ багш, Гагай заргач хоёрт монгол үсэгт суурилан манж бичиг зохиохыг даалгаснаар Манжууд бичиг үсэгтэй болжээ. Гэвч манж үсэг, бичгийг зохиох ажил 30 гаруй жил үргэлжлэн, энэ тэр хугацаанд монгол үсгийг бараг хэвээр нь хэрэглэж манж үгээ тэмдэглэж байсан бөгөөд уг үсгээ сүүлд нь “тонки фука аку хэргэн-и бидхэ” буюу “Дусал, бинтгүй бичиг” хэмээн Манжууд нэрлэдэг байв. Тиймээс Фонтанейн бичээд байгаа татар хэлээр бичдэг гэдэг нь монгол үсэг бичигт үндэслэсэн манж бичиг болно.

Судалгааны явцаас харахад “Дээрээс тогтоосон дүрс тус бүрийг бүртгэсэн бичиг” бүтээл Европын анатомийн бүтээлүүдэд суурилсан Өрнө-Дорны анагаах ухааны мэдлэгийг харгалдуулан бичсэн ховор ном бөгөөд Монголд Европын анагаах ухаан хүний биеийн бүтэц зүйн бүтээлээр дамжин дэлгэрч байсны гэрч хэмээн үзэх үндэстэй болно.

Бидний судалгааны гол хэрэглэгдэхүүн болох “Дээрээс тогтоосон дүрс тус бүрийг бүртгэсэн бичиг” зохиолын эх бичгийн боть, дэвтэр, бүлэг, хэсэг бүрийг нягтлан үзэхэд тэр үеийн судлаач мэргэд хүний биеийн бүтцийг задлан шинжлэн судлахдаа өрнө дахины анагаах ухааны арга зүйн зарчмуудыг ашиглахын тулд эхлээд маш олон ном бүтээлтэй танилцан уншиж мэдлэг олж аваад, тэрхүү аргаараа цаазлагдсан хүний салгуу толгой болон биеийг задлан шинжилж үзээд уг бүтээлдээ бичихдээ дорнын анагаах ухааны онол арга зүйн зарчмыг баримтлан бичиж туурвисан болох нь тодорхой болж байна. Ийм ч учраас өрнийн анагаах ухааны биезүй буюу анатомийн судалгааны гол бүтээл болох А.Везалий “De Humani Corporis Fabrica” нэртэй долоон номын [11] гарчиг, бүлэг, хэсгийн дараалалтай эрс зөрөөтэй боловч зарим нэгэн зургийн ерөнхий төрх байдал ойролцоо ч үлгэр загвар, арга барил ондоо болох нь, мөн зураас болон барын хэвийн дардас хоёр нь ялгаатай байгаа болно.

А.Везалийн “De Humani Corporis Fabrica” номын бүх зураг тайлбарыг түүний авьяаслаг шавь Тициана-Иоган Стефан Калькар зурахдаа өргөн нарийн зураасаар илэрхийлж, уран зураглал, цогцсыг амьдчлах байдлаар зурсан нь яс, булчингийн зургуудаас улам ч тодорхой харагддаг. Түүнээс нэг зуу орчим жилийн өмнө бүтээлээ туурвиж байсан Леонардо да Винчи хүний бие цогцсыг задлан шинжлээд түүнийгээ

дүрслэн зурж, бичиж үлдээхдээ бодит байдалд илүү ойр хийгээд дотоод агуулгыг илэрхийлэн гаргах арга зүйг баримталсан нь бас л тодорхой харагддаг. Гэтэл “Дээрээс тогтоосон дүрс тус бүрийг бүртгэсэн бичиг” бүтээлийг туурвигчид номынхоо зураг чимэгт бодит байдал, зөв дүр төрхийг яг байгаагаар нь илэрхийлэхийн тулд зураас болон сүүдэр гаргахдаа бийрийн янз бүрийн хэлбэрийг ашигласан бөгөөд тийм зургаа бард мөн тэрхүү байдлаар сийлбэрлэн оруулсан нь бусдаас онцлог ялгаатай болсон гэж үзэх үндэстэй байна.

Бидний үзэж байгаагаар энэхүү 2 боть, 6 дэвтэр бүтээлийг туурвихдаа Энэтхэг, Хятадын анагаах ухаан буддын гүн ухааны үндсэн иш онол “гурван доша”, “гурван гэм”, таван махбод, “ин-ян” хийгээд “арга-билиг”-ийн сургаалыг баримтлан туурвисан болох нь хоёр ботийн аль алинд тодорхой байна. Мөн Төвөд эмнэлэгт хэрэглэдэг эмийн бодисыг ихэвчлэн төвөд нэрээр галиглан хэрэглэжээ. Жишээ нь: агар, анар, билба, бигван, бор загдан, талгадорж, даръяаган, сэяв, сүгмэл, гүгэл, задь, гавар, жамбрай, гүргэм, лиш, бругар зава, жумз, сэрү зэрэг төвөд нэр, виши, сархана, шор, нируха зэрэг санскрит нэр, бин, дин, хин, и, лан, цэн зэрэг хятад нэр, мента, малва, валериан, оливийн тос, салвиа, фервенс, фервена гэх мэт латин нэрийг нь галиглан бичсэн зэргийг дурдах байна.

“Дээрээс тогтоосон дүрс тус бүрийг бүртгэсэн

бичиг”-ийн доод ботийн 2 дэвтэрт буй өвчний үеийн үйл ажиллагааны өөрчлөлтийн зүй тогтлыг зохиогч нар өөр өөрсдийн ойлгосноор дорно дахины танин мэдэхүйн сургаалыг ашиглан тайлбарласан байх юм. Жишээлбэл: цусан хийн өвчин, халуун-хүйтэн өвчин, хийн хөдөлгөөн хэрхэн өөрчлөгдөх гэх мэт. Эмчилгээний аргын хэсэгт дэлхийн янз бүрийн орны эмч нарын эмчилгээнд хэрэглэсэн аргуудыг зарим үед зохиогчоор нь (145 v) нэр зааж, зарим үед зохиолоор нь (30r, 115r) нэр зааж, мөн зарим үед бас нэгэн арга (162r, 163r) гэх жишээтэйгээр дурдан оруулжээ. Мөн эмчилгээний аргын дотор төвөд болон санскрит хэлээр бичих жишээ нь: нируха тавих гэх (13r) юмуу, монгол эмчилгээний өвөрмөц арга болох хануурын талаар элгэнээс болсон бөгөөс баруун гарын, дэлүүнээс болсон бөгөөс зүүн гарын судсыг ханах (20r) гэх юмуу, гал соруул (20r) зэрэг заслын талаар тэмдэглээд, эмийн талаар өгүүлэхдээ чанар нь сэрүүн (19r), исгэлэн халуун чанарт (46r) мөн эмийн хэлбэрийг ханд, үрэл (15r), мөхлөг хийж (162c) гэх, эмийн түүхий эдийн талаар зарим ургамлын зургийг тавьж ямар газар ургадгийг нь тэмдэглэжээ [12].

Судалгааны ажлын дараагийн хэсэг Монгол Улсад хадгалагдаж буй “Дээрээс тогтоосон дүрс тус бүрийг бүртгэсэн бичиг” болон Өвөр Монголд 1929 онд анх хэвлүүлсэн “Зарлигаар тогтоосон хэ ти чиуван лу бичиг” номын хэвлэгдсэн байдал, бүтцийг харьцуулан үзэв (Хүснэгт 1).

Хүснэгт 1. ДТДТБББ болон ЗТХТЧЛБ номын бүтцийн харьцуулалт

Харьцуулах сэдэв	Харьцуулсан бүтээлүүд	
	Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг Б.Ринчен, эрх. ШУА-ийн Хэвлэх үйлдвэр, 1971	Зарлигаар тогтоосон хэ ти чиуван лу бичиг Балдандончир, хян. ӨМ-ын ШУТМХХ, 1986
Хэвлэлийн нэр	Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг	Зарлигаар тогтоосон хэ ти чиуван лу бичиг
Хэвлэгдсэн улс	Монгол	Хятад
Хэвлэгдсэн үйлдвэр	БНМАУ, Шинжлэх Ухааны Академийн хэвлэх үйлдвэр	БНХАУ, Өвөр Монголын Шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо
Хэвлэгдсэн он	1971 оны 10 сар	1986 оны 09 сар
Хэвлэл	3 боть ном Нэг: Дээд боть, тэргүүн, нөгөө дэвтэр-135 нүүр Хоёр: Дээд боть, гутгаар, дөтгөөр дэвтэр -188 нүүр Гурав: Доод боть, тэргүүн дэд дэвтэр -176 нүүр	1 боть ном 208 нүүр Оршил хэсэг - 27 нүүр Тэргүүн дэвтэр - 33 нүүр Дэд дэвтэр - 44 нүүр Гутгаар дэвтэр - 41 нүүр Дөтгөөр дэвтэр - 63 нүүр

Боть ба дэвтэр	Дээд боть-Тэргүүн, нөгөө, гутгаар, дөтгөөр гэсэн 4 дэвтэр Доод боть- тэргүүн, дэд гэсэн 2 дэвтэртэй.	Дээд ботийн эхлэл 3 хэсэг сэдвээс бусад буюу Биеийн бүтцийн сэдвүүд багтаагүй, доод боть дахь хэсгийг л оруулсан. Үндсэн 4 дэвтэртэй
Хавсралт	Зарим ургамлын зүйлийн тодруулгыг тухай бүрт нь бичсэн	Хавсралтгүй
Гарчгийн нэр	Зүйл ба анги	Гарчиг

Энэхүү хоёр бүтээлийн харьцуулалтаас үзэхэд төсөөтэй тал ганцхан байна. Үүнд: “Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг”-ийг Өвөр Монголчууд “Зарлигаар тогтоосон хэ ти чиуван лу бичиг” гэж орчуулсан номынхоо хавтсан дээрээ бичжээ. Харин дотор талд нь “Зарлигаар тогтоосон гадаад улсаас уламжилсан хэ ти чиуван лу бичиг” хэмээн гадаад улсаас уламжлагдсан гэдгийг онцлон илэрхийлжээ.

Дээрээс тогтоосон, зарлигаар тогтоосон гэдэг нь агуулгын хувьд адилхан хааны зарлиг, шийдвэрээр гэсэн үг юм. Харин “Хэ ти чиуван лу бичиг” нь “Ge ti ciovan lu bithe” гэсэн манж гарчгийн галигчлан аваад сүүлийн “bithe”-ээг бичиг гэж монголчилжээ [13]. Нэмээд хэлэхэд Ар Монголоос олдсон бүтээлийн “Дээрээс тогтоосон” хэмээх нь манж эхийн “Dergici toktobuha” гэснийг шууд авч хэрэглэсэн байна.

Ялгаатай тал нэн их буй. Хэвлэсэн улс Монгол, Хятад байхаас гадна ДТДТБББ бүтээл нь 3 боть ном. Үүнд: Нэг: дээд боть, тэргүүн, нөгөө дэвтэр-135 нүүр, Хоёр: Дээд боть, гутгаар,

дөтгөөр дэвтэр -188 нүүр, Гурав: Доод боть, тэргүүн дэд дэвтэр -176 нүүр ном байна.

Гэтэл ЗТХТЧЛБ бүтээл 1 боть ном 208 нүүр, оршил хэсэг - 27 нүүр, Тэргүүн дэвтэр - 33 нүүр, Дэд дэвтэр - 44 нүүр, Гутгаар дэвтэр - 41 нүүр, Дөтгөөр дэвтэр - 63 нүүртэй байгаа нь ДТДТБББ-ээс дутуу өөрөө хэлбэл ЗТХТЧЛБ бүтээлд дээд ботийн эхлэл 3 хэсэг сэдвээс бусад буюу биеийн бүтцийн сэдвүүд багтаагүй, доод боть дахь хэсгийг л оруулжээ. ДТДТБББ номонд зарим ургамлын зүйлийн тодруулгыг тухай бүрт нь бичсэн байтал ЗТХТЧЛБ-т хавсралт байхгүй байна. Үүнээс дүгнэхэд “Зарлигаар тогтоосон хэ ти чиуван лу бичиг” нилээд дутуу болох нь тогтоогдохын зэрэгцээ “Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг” бүтээл манж эхийн дагуу ёсчлон орчуулсан бүрэн орчуулга болох нь харагдаж байна.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд “Дээрээс тогтоосон дүрс тус бүрийг бүртгэсэн бичиг” болон “Зарлигаар тогтоосон хэ ти чиуван лу бичиг” номын зарим агуулга, нэр томьёог харьцуулан судлав (Хүснэгт 2).

Хүснэгт 1. ДТДТБББ болон ЗТХТЧЛБ номын зарим агуулга, нэр томьёог харьцуулалт

№	Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг Доод боть. <u>Тэргүүн Дэвтэр</u>	Зарлигаар тогтоосон гадаад улсаас уламжилсан хэ ти чиуван лу бичгийн үүдвэр учрыг тэмдэглэсэн <u>анхан дэвтэр</u>
	<u>Хүний өвчин эмгэгийн уг шалтгааныг эхлэн өгүүлэх нь</u>	<u>Хүний өвчин эмгэгийн уг учрыг үүсгэн өгүүлсэн нь</u>
1	Эмчлэн засах зүйл хэмээвээс, хүний амин биеийг аврах нь маш тустай хэрэг буюу.	Эмчлэн засах зүйл хүний амь биеийг тэнхрүүлэн маш тустай хэрэг болой.
2	Түүнд оролцсон нь чухал хэрэгт буй.	Түүний холбогдсон нь хүнд /хүчир/ чухал.
3	Эртний ардын зохиосон судар бичгийг бүрнээ үзвээс, үеийн үеэс уламжилсан эмчийн ёс нь, ер нэг цагт сурсан бус, бас гагц нэг хүний зохиосон ч бус буюу.	Эртний ардын хоцроосон бичиг хард дараалан үзвээс үе үеэс уламжлан ирсэн эмч нарын дотор огт нэг цагт олсон нь бус бөгөөд бас нэг хүний төдий л зохиосон нь бус.
4	Эрт урьдын цагт, өвчнийг засах зүйлгүй бөлгөө.	Балар эртний цагт өвчнийг засах зүйлгүй бөлгөө.
5	Тэр цагийн мэргэд, өвчит хүнийг энэрэн өршөөх сэтгэл үүсгэж, зүйл бүрээр тэнсэж засахад нэг нэгэнд өвчинд нийлэлдэж, өвчнийг сайн болгоод сац, даруй бичиж тэмдэглэсний тул, түүнээс уламжлан ирсээр зүйл бүр өвчинд, зүйл бүрийн засах аргыг зохиов.	Тэр цагийн мэргэд өвчтөн хүнээ энэрэн өршөөж санаа төвдөхгүй. Зүйл зүйлээр тэнсэн засах завшаанд өвчинд тохиолдоод өвчин өнгөрсний хойно даруй бичиж тэмдэглэх тул түүнээс уламжлан ирсээр зүйл бүрийн өвчинд зүйл бүрийн заслага зохиожээ.

6	Хойно Ге-рви-ший-еэ $\frac{1}{2}$ $\frac{1}{2}$ $\frac{1}{2}$ $\frac{1}{2}$ улсын Эс-хиуй-лав $\frac{1}{2}$ $\frac{1}{2}$ $\frac{1}{2}$ нэрт хүний үед хүрч ирээд сац, чин үнэн сэтгэлээр эмчийн ёсыг хичээж, хүний өвчнийг зассаар, нэр алдаршсан бөлгөө.	Хожим Гэ-ри-ший-еэ $\frac{1}{2}$ $\frac{1}{2}$ $\frac{1}{2}$ $\frac{1}{2}$ улсын Эс-жуй-лав $\frac{1}{2}$ $\frac{1}{2}$ $\frac{1}{2}$ нэртэй хүнд хүрч ирээд санаа шийдэж эмчийн ёсыг хичээн хүний өвчнийг зассаар нэр алдар гарав.
7	Түүний өнгөрсний хойно, хамаг хүн гомдон гэмшиж, чулуугаар дүрсийг үүдэж тахив.	Нөгчсөний хойно олон хүн нэхэн санаж чулуун хөрөг босгож тахижээ.
8	Түүний ахмад хөвгүүн Ма-ка-он $\frac{1}{2}$ $\frac{1}{2}$ $\frac{1}{2}$ $\frac{1}{2}$ эцгийн ёсыг залгамжилж, үеийн үед уламжлан өвчнийг засаж, мянган он болсны хойно, түүний арван наймдугаар үеийн ач, Эй-бо-гве-ре-дис $\frac{1}{2}$ $\frac{1}{2}$ $\frac{1}{2}$ $\frac{1}{2}$ $\frac{1}{2}$ ийн үед мөнхүү түүний, элэнцээс уламжилсан зүйл бүрийн аргыг хураагаад, нэг газар нийлүүлж, бас өөрийн биеэр тэнсэж зассан аргыг нэмж, бүлэг хэсэг болгон өөр өөр ялгаж тулгуур бичиг зохиогоод, сурагч ардад, өөр өөр зааж сургаснаар, эмчлэн засах ёсоор, ертөнцөд тодорч, нэр нь нэн алдаршив.	Үүний ахмад хөвгүүн Ма-ка-өн $\frac{1}{2}$ $\frac{1}{2}$ $\frac{1}{2}$ $\frac{1}{2}$ өөрийн эцгийн ёсыг залгамжлан үе улиран өвчнийг засаж мянган жил болсон хойно түүний арван наймдугаар үеийн ач Ай-бо-ге-ре-тес дор $\frac{1}{2}$ $\frac{1}{2}$ $\frac{1}{2}$ $\frac{1}{2}$ $\frac{1}{2}$ хүрч ирээд тэдний дээд өвгөдөөсөө уламжлан ирсэн зүйл зүйлийн заслагыг хураан аваад нэг газарт нийлүүлэн бас өөрийн биеийн тэнсэж өнгөрсөн заслагыг нэмж зүйл ангийг ялган салгаад анхан бичиг зохион бичиж сурах ардад тус тус заан ухуулсан учирт эмчлэн засах ёс сая ертөнцөд илрээд, нэр нэн алдаршжээ.
9	Энэ Эй-бо-гве-ре-дис $\frac{1}{2}$ $\frac{1}{2}$ $\frac{1}{2}$ $\frac{1}{2}$ $\frac{1}{2}$ нэг зуу насалсан бөлгөө.	Энэ Ай-бо-ге-ре-тес $\frac{1}{2}$ $\frac{1}{2}$ $\frac{1}{2}$ $\frac{1}{2}$ $\frac{1}{2}$ нэг зуун есөн нас олов.
10	Түүний өнгөрснөөс янагш, эдүгээ хоёр мянга тавин зургаан он болов.	Нөгчсөнөөс янагш эдүгээ хоёр мянга бөгөөд тавин зургаан он болжээ.
11	Үүний хөвгүүн ач нар бас хоёр зуун он илүү энэ ёсыг дагаж явсаар, газар газраа өвчнийг засах сургууль байгуулж, шавь нарыг сургаж өвчний зүйл ба эмийн чанар ялган өгүүлэлдэж, хичээн танижээ. Зарим өвчин танихад бэрхийн тул, түүгээр амьд гөрөөс жигүүртнийг яраад хэвлийг хагалж, зүрх ба элэг, уушги, гэдэс дотор, шөрмөс, судал тэргүүтний зүйлийн барилдсаныг нарийвчлан үзэв.	Түүний хөвгүүн ач нар бас хоёр зуун жил илүү энэ ёсыг журамлан явж газар газарт өвчин засах сургууль байгуулаад шавь нарыг сурган өвчний зүйл ба эмийн чанарыг ялган шүүмжилж хянан таниж зарим нэг өвчний учрыг огт танихад бэрх тул түүнээс амьд шувуу, гөрөөсийг хагалан нээж зүрх, элэг, гэдэс дотор, судал шөрмөсний зэргийн зүйлийн холбон төрснийг нарийвчлан үзэв.
12	Бас эртнээс уламжилсан эм ба аргаас өөр, зүйл бүрийн өвс модны чанарыг хянан ялган тэнсэж үзээд, эмд найруулж болохыг нэг нэгээр дүрэмлэн зурж, тайлж номлосныг бичээд, бичигт зохиов.	Бас язгуураас уламжлан ирсэн эмийн заслагаас гадна элдэв өвс модны чанарыг хянаж ялгаад тэнсэн үзэж эм найруулж болохыг нь нэг нэгээр дүрслэн зураад тайлбарлан өгүүлсэн явдлыг оруулан бичиж зохиожээ.
13	Бас алт, мөнгө, гууль, төмөр тэргүүтэн газрын сангаас гарсан ба, гөрөөс жигүүртэн ба, загас, хорхой тэргүүтэн амьтны дотор, эмэнд найруулж болохыг бас урьд ёсоор тайлж номолсныг бичиж, бичигт зохиов.	Басхүү алт, мөнгө, гууль, зэс, төмөр ба ордоос гарсан зэргийн зүйл жич шувуу, гөрөөс ба загас, хорхойн зэргийн амьтны дотор эм найруулваас болохыг нь мөн урьд ёсоор тайлбарлан өгүүлсэн явдлыг оруулан бичээд бичиг зохиожээ.
14	Тэр цагаас эдүгээ хүртэл уламжилсны тулд улам улам бадруулж нэмсээр хойд үед хүрч ирээд, эмчлэн засах ёс нь ер ихэд дэлгэрэв.	Тэр цагаас энэхүү ёс нэгэнт дэлгэрсний тулд дараа дараагаар бадруулан нэмэгдсээр хойчийн үед хүрч ирээд эмчлэн засах ёс сая ихэд хөгжжээ.
15	Эдүгээх цагийн мэргэд сэтгэлээ зовж, нарийвчлан хичээн дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичгийг тодорхойлон зохиосон нь, чухам хүний өвчний шалтгааныг мэдтүгэй хэмээхийн тул буй.	Эдүгээгийн мэргэд эрдэмтэн санаа үлдээж нягтлан хянаж Хэ-ти-чиуван-лу $\frac{1}{2}$ $\frac{1}{2}$ $\frac{1}{2}$ $\frac{1}{2}$ бичгийг тодорхойлон зохиосон нь чухам хүний өвчний учрыг мэдтүгэй хэмээсэн учир буюу.
16	Хэрвээ өвчний зүйлийг ялган нээж эс өгүүлвээс, дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичгийн үйлс хэрэггүй болох ч болмой.	Хэрвээ өвчний зүйлийг сэнхрүүлэн салгаж өгүүлэхгүй болвоос Хэ-ти-чиуван-лу $\frac{1}{2}$ $\frac{1}{2}$ $\frac{1}{2}$ $\frac{1}{2}$ бичгийн сүйтгэл талаар болоход хүрмой.
17	Иймийн тул толгойноос дорогш, хөлөөс дээш, өвчний зүйлийг хойно гаргаж өгүүлэв.	Иймийн тул тэргүүнээс дорогш, хөлөөс дээших өвчний чухал явдлыг хойно гарган өгүүлжээ.

Тус харьцуулалтад гарч буй гадаад үгнүүд буюу хүний нэр, ургамлын нэр, зарим өвчний нэрс нь монгол бичгээр бичигдсэн байдал ондоо байгаа нь хятад ханзаар бичигдсэн эхээс галиглан орчуулсанд буй хэмээн үзэж байна.

Түүнчлэн харьцуулалтад авсан 17 зүйлд агуулга нь яг адил нэг ч хэсэг алга байна. Зүйл тус бүрт үндсэн нэр томъёог өөр өөрөөр орчуулжээ. Жишээлбэл: “Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг”-т: Доод боть, Тэргүүн дэвтэр, Хүний өвчин эмгэгийн уг шалтгааныг эхлэн өгүүлэх нь гэсэн байхад “Зарлигаар тогтоосон гадаад улсаас уламжилсан хэ ти чиуван лу бичиг”-ийн үүдвэр учрыг тэмдэглэсэн анхан дэвтэр: Хүний өвчин эмгэгийн уг учрыг үүсгэн өгүүлсэн нь гэж орчуулжээ.

Гарчгийн энэ хэсэгт ДТДТБББ-т “Өвчин эмгэгийн уг шалтгааныг эхлэн” хэмээн харин ЗТХТЧЛБ-т “Өвчин эмгэгийн уг учрыг үүсгэн” гэж ялгаатай орчуулжээ. Шалтгаан нь юмны учир, чанарын ялгаа, үүсгэл холбогдол харин уг учир нь хэрэг явдлын уг үүсэл, байдлыг заасан утгатай. Нарийн үзвэл төдийлөн ялгаагүй мэт. Гэвч өвчний хувьд шалтгаан нь уг учир гэдгээс илүү зохилдсон, оновчтой байхаас гадна, хүний өвчин зовлонгийн үүслийн язгуурыг илэрхийлэх чадвар нь нэн илүү гэж үзлээ. Уг учир нь хүмүүнд гэхээсээ илүү юмс үзэгдлийн цаад мөн чанарыг илэрхийлсэн үг юм.

ДТДТБББ болон ЗТХТЧЛБ- бүтээлийн хэвлэгдсэн байдал, бүтэц, зарим агуулга, нэр томъёоноос үзэхэд уг хоёр орчуулга хоёр өөр газарт, өөр өөр орчуулагч нар, өөр өөр цаг хугацаанд орчуулсан болох нь илэрхий байна.

Эртний Монгол аймгууд урт хугацааны туршид өвчин эмгэгийг эмчлэх янз бүрийн аргыг үүдэн бүтээж, үеэс үед дамжуулан туршлагаа хуримтлуулсаар хүний биеийн бүтэц, эмчлэх, эрүүл амьдрах ухааны бие даасан тогтолцоог бий болгожээ. Энэхүү тогтолцоо нь хөгжлийн явцад Энэтхэг, Төвөд, Араб болон Европийн анагаах ухааны мэдлэгээр баяжигдсаар ирсэн байна [14]. Цаашид Европын анагаах ухааны эмнэлгийн тусламж Монгол үндэстэнд хэдийд дэлгэрсэн түүхийг судлах, эх сурвалжийг судалгааны эргэлтэд оруулах талаар өргөн хүрээтэй судалгаа хийх шаардлагатай нь бидний судалгаанаас харагдаж байна.

Ном зүй

1. French Jesuits and the “Manchu Anatomy” – how missed the Vesalian Revolution. CMAJ•JAMC. 1974 Sep 21; 111(6): 565-6, 568.
2. Болд.Ш, Болорцэцэг.Ж. Европын анагаах ухаан монголд дэлгэрсэн түүхийг тодруулах нь. Монголын анагаах ухаан УБ, 2018, №1 (183), х.51-57
3. Pierre Dionis. Anatomie de l'Homme. Forgotten Books. 2018, 740 pages
4. Thomas Bartholin. Anatome ex omnium veterum recentiorumque observationibus. Forgotten Books. 2018, 882 pages
5. Дээрээс тогтоосон дүрс тус бүрийг бүртгэсэн бичиг. (эрх. Б.Ринчен). ШУА-ийн Хэвлэх үйлдвэр, УБ, 1971
6. Зарлигаар тогтоосон хэ ти чиуван лу бичиг. (Хян. Балдандончир). БНХАУ, ӨМ-ын ШУТМХ, 1986
7. Андреас Везал. De humani corporis fabrica. Хүний биеийн бүтцийн 7 боть ном.
8. Болд.Ш, Болорцэцэг.Ж. Европын анагаах ухаан монголд дэлгэрсэн түүхийг тодруулах нь. Монголын анагаах ухаан. УБ, 2018, №1 (183), х.51-57
9. Dergici toktobuha ge ti ciovan lu bithe. Манж хэлээр бичсэн гар бичмэл хуулбар ном
10. French Jesuits and the “Manchu Anatomy” – how missed the Vesalian Revolution. CMAJ•JAMC. 1974 Sep 21; 111(6): 565-6, 568.
11. Андреас Везал. De humani corporis fabrica. Хүний биеийн бүтцийн 7 боть ном.
12. Дээрээс тогтоосон дүрс тус бүрийг бүртгэсэн бичиг. (эрх. Б.Ринчен). ШУА-ийн Хэвлэх үйлдвэр, УБ, 1971
13. Зарлигаар тогтоосон хэ ти чиуван лу бичиг. (Хян. Балдандончир). БНХАУ, ӨМ-ын ШУТМХ, 1986, х.6
14. Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны түүх. УБ, 2016, х.15

Танилцаж, нийтлэх санал өгсөн:

*Анагаах ухааны доктор, профессо
Д.Цэрэндагва*